

СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

БАЛАНС		/төгрөгөөр/		
А. ХӨРӨНГӨ	2008	2009	2010	2011 Q2
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	128,733,317	18,060,895	16,940,500	52,106,257
Дансны авлага	222,813,606	2,095,073,758	345,598,844	184,638,902
Найдваргүй авлагын хасагдуулга	-	-		
Бусад татварын авлага		3,204,489		
Бусад авлага			217,800	
Бараа материал	5,068,403,113	8,196,365,925	3,313,597,149	2,876,561,466
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	-	-		96,490,343
Салбаруудын тооцоо			1,900,000,000	1,066,883,993
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,419,950,037	10,312,705,067	5,576,354,293	4,276,680,963
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	17,151,258,000	20,322,578,160	20,883,624,889	32,044,297,532
Хуримтлагдсан элэгдэл		-408,392,026	-917,962,901	-200,326,993
Бусад үндсэн хөрөнгө	6,836,670,101	10,018,327,778	11,654,545,739	13,490,059,641
Хуримтлагдсан элэгдэл	-42,770,053	-735,497,819	-1,556,698,211	-535,138,103
Дуусаагүй барилга		101,735,623	2,524,374,686	2,2569,520,200
Биет бус хөрөнгө	3,953,871	3,953,871	3,953,871	3,953,871
Хуримтлагдсан элэгдэл		-395,387	-790,774	-988,467
Хөрөнгө оруулалт ба бусад				2000,000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	23,949,111,919	29,302,310,200	32,591,047,298	47,373,377,679
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	29,369,061,956	39,615,015,267	38,167,401,591	51,650,058,643
Б. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч				
Дансны өглөг	602,041,664	2,819,494,978	1,025,513,169	420,466,973
Цалингийн өглөг				
ОАТатварын өглөг	3,449,132		20,504,560	8,563,936
ХАОАТ-ын өглөг	5,786,140	6,342,867	987,460	127,696
НӨАТ-ын өглөг			-	
Бусад татварын өглөг				
ЭМНДШ-ийн өглөг	5,657,547			169,405
Ногдол ашгийн өглөг				
Банкны богино хугацаат зээл			1,900,000,000	2,815,000,000
Бусад өглөг				
Урьдчилж орсон орлого			116,170,108	127,830,009
Богино хугацаат өглөг/салбарын	4,988,955,225	7,109,912,733	2,469,871,858	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,605,889,706	9,935,750,577	5,533,047,154	3,372,158,019
Урт хугацаат өр төлбөр	16,984,335,300	24,982,391,094	28,237,845,242	468,187,241
Урт хугацаат зээл				
Бусад урт хугацаат өглөг				
Урт хугацаат өр төлбөрийн дүн	16,984,335,300	24,982,391,094	28,237,845,242	468,187,241
Өр төлбөрийн нийт дүн	22,590,225,006	34,918,141,671	33,770,892,396	3,840,345,261
Эзэмшигчдийн өмч				



Өмч: хувийн	10,000,000	10,000,000	10,000,000	28,247,845,242
Хувьцаат капиталын дүн	10,000,000	10,000,000	10,000,000	28,247,845,242
Дахин үнэлгээний нөөц	11,554,795,132	11,554,795,132	11,129,775,386	26,567,984,661
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг				
Хуримтлагдсан ашиг /алдагдал			-6,743,266,192	-7,006,116,520
Тайлангийн үеийн	5,529,488	-2,081,963,354	123,340,997	64,042,787
Өмнөх үеийн	-4,791,487,671	-4,785,958,183	-6,866,607,189	-7,070,159,308
Эзэмшигчдийн өмчийн дүн	6,778,836,949	4,696,873,595	4,396,509,195	47,809,713,382
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	29,369,061,956	39,615,015,267	38,167,401,591	51,650,058,643

Хүснэгт 14 Баланс



ОРЛОГЫН ТАЙЛАН				/төгрөгөөр/
<i>ҮЗҮҮЛЭЛТ</i>	<i>2008</i>	<i>2009</i>	<i>2010</i>	<i>2011 Q2</i>
Борлуулалтын орлого	7,669,353,855	10,309,506,115	17,799,654,295	3,675,716,415
Борлуулалтын хорогдол ба буцаалт	-27,210,995	1,678,903	1,871,418	
Борлуулалтын хөнгөлөлт		400,217		
Борлуулалтын орлогын дүн	<u>7,642,142,860</u>	<u>10,307,426,996</u>	<u>17,797,782,877</u>	<u>3,675,716,415</u>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,992,702,491	6,000,055,274	8,874,999,731	1,712,994,699
Нийт ашиг /алдагдал/	<u>2,649,440,369</u>	<u>4,307,371,722</u>	<u>8,922,783,146</u>	<u>1,962,721,716</u>
Үндсэн болон нэмэгдэл цалин	693,125,611	1,063,419,166	1,130,814,909	393,447,463
Нийгмийн даатгалын шимтгэл	78,123,971	131,998,154	138,141,175	55,128,365
Засвар үйлчилгээний зардал	90,221,773	96,783,654	210,313,205	33,724,712
Ашиглалтын зардал	199,007,038	291,336,294	309,184,324	49,615,540
Түрээсийн зардал	36,223,655	39,265,624	34,611,250	13,566,831
Албан томилолтын зардал	62,859,803	72,208,795	46,082,427	16,077,346
Тээврийн зардал	174,443,284	227,043,963	151,170,616	7,729,200
Түүхий эд материалын зардал	11,767,660	24,543,825	28,766,066	
Элэгдлийн зардал	759,720,590	1,102,551,568	1,434,607,603	860,460,048
Зар сурталчилгааны зардал	14,985,689	21,464,051	10,694,214	3,723,970
Шуудан, холбооны зардал	21,422,687	23,860,239	15,280,029	7,250,475
Шатахууны зардал	170,901,138	378,164,246	240,541,891	37,979,031
Найдваргүй авлагын зардал			9,040,522	
Зээлийн хүүгийн зардал	550,735,409	3,174,908,815	4,910,534,681	207,150,904
Бусад зардал	420,185,807	508,465,733	484,368,011	188,845,191
Үйл ажиллагааны зардлын дүн	<u>3,283,724,114</u>	<u>7,156,014,125</u>	<u>9,154,150,925</u>	<u>1,874,915,537</u>
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	<u>-634,283,746</u>	<u>-2,848,642,404</u>	<u>-231,367,779</u>	<u>87,806,178</u>
Үйл ажиллагааны бус орлого	668,775,061	826,185,982		
Үйл ажиллагааны бус зардал	25,512,696	59,506,933		-13,852,973
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдал/-ын дүн	<u>643,262,365</u>	<u>766,679,050</u>	<u>375,218,337</u>	<u>-13,852,973</u>
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	<u>8,978,619</u>	<u>-2,081,963,354</u>	<u>143,850,557</u>	<u>73,953,206</u>
Орлогын татварын зардал	3,449,131,50	-	20,509,560	9,910,418
Татварын дараах ашиг /алдагдал/	<u>5,529,488</u>	<u>-2,081,963,354</u>	<u>123,340,997</u>	<u>64,042,787</u>

Хүснэгт 15 Орлогын тайлан



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Үнэт цаас гаргагч нь “Далайван Аудит” ХХК-тай гэрээ байгуулан 2010 оны жилийн эцсийн, 2011 оны 1 болон 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хараат бус аудиторроор ажиллуулсан.

2011 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн дүгнэлт**ДАЛАЙВАН АУДИТ**

Аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө,
хөрөнгийн үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага

Монгол Улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 305401, 99006277, 99008659
Факс: +976-11305403
Э.шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

АУДИТОРЫН ТАЙЛАН**“Жаст Агро” ХХК-н Гүйцэтгэх
захирал Т.Содномдаржаа танаа**

Бид “Жаст Агро” ХХК-н (цаашид “Компани” гэх) 2011 оны 06 дугаар сарын 30-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон мэдэгдэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгуудад гэрээний дагуу аудит хийлээ.

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлага байна. Энэхүү үүрэг хариуцлагад алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх ба үнэн зөв толилуулахад холбогдох дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх үүргүүд орно.

Бид хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангийн талаар хараат бус зөвлөмж гаргах нь аудитын үүрэг байна. Аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангууд дахь дүн, тодруулгуудын дагалдах нотолгоог олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орсон болно.

Аудитын явцад бид өмнөх он болон 2011 оны 1-р улиралд илэрсэн алдаа, зөрчил дутагдал, тэдгээрийг арилгахтай холбогдуулан компанийн ерөнхий удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтыг гаргуулан авч, тухайн тайлангийн хугацаанд компанийн гүйцэтгэх удирдлагын хийсэн томоохон дүнтэй тооцооллууд ба баримталсан нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг үнэлэх, түүнчлэн санхүүгийн тайлангуудын ерөнхий толилуулгад үнэлэлт өгөх ажлууд орсон. 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулахад эдгээр ажлын хүрээнд хийгдсэн үр дүн чухал нөлөө үзүүлэх болно.



Ажлын тэмдэглэл:

1. 2011 оны 2-р улиралд хийгдсэн томоохон дүнтэй гүйлгээний талаар:
 - 1.1. “Мах Маркет интернейшл” , “Хатан суман” гэсэн 2 компанийг “Жаст Агро” ХХК нь өөрийн охин компани болгон бүртгүүлснээр хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн.
 - 1.2. “Хатан суман” ХХК-тай 2010 оны 12-р сарын 20-ны өдөр “Зээл шилжүүлэн ашиглах гэрээ”-р 7.5 тэрбум төгрөгний зээлийг “Жаст групп” ХХК-тай байгуулсан бөгөөд үүний 915,000.0 мянган төгрөгийг “Жаст Агро” ХХК нь ашиглаж байна. Энэ зээлийн дүнгээр банкны богино хугацаат зээлийн үлдэгдэл нэмэгдсэн байна.
 - 1.3. “Хатан суман” ХХК-н Сэлэнгэ, Багануур Мах Боловсруулах үйлдвэрүүдийг “Өмч ашиглуулах гэрээ”-р “Жаст Агро” ХХК нь ашиглаж байна. Энэ тухай “Өмч ашиглуулах гэрээ”-ний үндсэн дээр бид дээрх үйлдвэрүүдийн ашиглалт, засвар үйлчилгээ, хадгалалт хамгаалалтыг бүрэн хариуцаж байгаа тул өөрсдийн санхүүгийн тайланд тусган бүртгэсэн гэж тус компанийн ажилтан тайлбарласан.
 - 1.4. “Жаст Агро” ХХК-н зүгээс бидэнд гаргасан тайлбараар компанийн дээрх үйл ажиллагаа нь тайлант оны турш үргэлжлэн явагдана гэсэн тул 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд үр дүн нь тусгагдах учир бид 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргахдаа илүү тодорхой тусгана.

2. Аудитын явцад 2010 оны жилийн эцэс болон 2011 оны 1-р улиралд санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг тус компанийн санхүү бүртгэлийн ажилтнуудаар гаргуулж авсан. Ингэхэд санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, эх үүсвэр, өртөг зардал, татварын тооцооллын талаар нийт 7 зөвлөмж өгөгдсөнөөс 5 зөвлөмжийг биелүүлэн ажилласан байна.

“JAI VAN-AUDIT” Co., Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Аудиторын туслах:

Ш.Нарантунгалаг



Удирдлагад хүргүүлэх энэхүү захидлаар өмнөх тайланд тусгагдсан хязгаарлалт

Зөвлөмжийн хэрэгжилт

Санхүүгийн тайлагналын талаар

1. Тус компанийн өнөөгийн болон ойрын төлбөрийн чадварын шинжилгээг хийхэд доорхи үзүүлэлттэй байна.
 - Эргэлтийн хөрөнгийн харьцаа 1:1
 - Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 0.1



- Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа 0.003

Дээрхи үзүүлэлтээс дүгнэхэд компани нь харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг цаг хугацаанд төлж барагдуулах чадвар муу байна.

2. Валютаар илэрхийлсэн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны албан ханшаар тэгшитгэл тооцож, валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй олз, гарз бүртгээгүй байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Компанийн өнөөгийн болон ойрын төлбөрийн чадвар муу байгаа шалтгааныг тодруулан удирдлагад танилцуулж шийдвэр гаргуулан компанийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх,
2. “Нягтлан бодох” бүртгэлийн тухай хуулийн 9-р зүйл, “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичигт зааснаар валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг Монгол банкны албан ханшаар илэрхийлж, валютын ханшийн зөрүүний олз гарз тооцож байх.

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Төлбөрийн чадварын харьцаа 2010 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад сайжирсан дүнтэй байна.
2. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
3. Зөвлөмжийн дагуу ханшийн тэгшитгэлийг Монгол банкны ханшаар илэрхийлсэн болно. Энэ хүрээнд гадаад валютаар үлдэгдэлтэй 2 харилцах дансны үлдэгдэл, 4 харилцагч байгууллагын үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийсэн.

Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар

1. Бэлтгэн нийлүүлэгчид урьдчилж төлсөн 12,099.6 мянган төгрөгийн урьдчилгааг дансны авлагаар тайлагнасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан 29,389,237.3 мянган төгрөгийн биет хөрөнгийг “Жаст групп” ХХК-тай 2010 оны 3 сарын 31-ний өдөр байгуулсан “Өмч шилжүүлэн ашиглуулах гэрээ”-ний дагуу ашиглаж байна.
3. Гэрээгээр ашиглаж буй хөрөнгийг компани нь зарж борлуулах, бусдад шилжүүлэх, барьцаалах эрхгүй бөгөөд энэ талаар зөвхөн санал гаргах эрхтэй ба гэрээг жил бүр дүгнэж, акт үйлдэн тайлант хугацааны хөрөнгийн хөдөлгөөнийг гэрээний хавсралтанд тусгадаг.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Бэлтгэн нийлүүлэгчдэд урьдчилж төлсөн урьдчилгааг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.4-ийн дагуу бүртгэж тайлагнах.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан үндсэн хөрөнгийн өмчлөлийн асуудлыг компанийн ерөнхий удирдлагад танилцуулан шийдвэр гаргуулан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.5-дахь тодорхойлолтод заасны дагуу үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж байх.

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Зөвлөмжийн дагуу 2011 оны 1-р улирлын тайланд урьдчилж төлсөн төлбөрийг “Урьдчилж гарсан зардал”-ын ангилалаар бүртгэв. Энэхүү тооцоонд 2 харилцагчийн 10,0 сая төгрөгийн тооцоог хамруулан бүртгэсэн.



2. Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн /шилжилт хөдөлгөөн, худалдан борлуулах, худалдан авах гэх мэт/ гаргах тухай бүр өмчлөгчөөс зөвшөөрөл хүсэж шийдвэрлэсний үндсэн дээр үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтөлж байна.

Эх үүсвэрийн талаар

1. Урт хугацаат өр төлбөрийн дансанд “Зээл шилжүүлэн ашиглах гэрээний дагуу 10 аж ахуйн нэгж, 2 хувь хүнээс авсан нийт 33,030.3 мянган ам.доллар, 2,000,000.0 мянган төгрөгийн зээлээр санхүүжигдэн 2006-2010 онуудад хийгдсэн тус компанийн харьяа мал, мах боловсруулах үйлдвэрүүдийн өргөтгөл, шинэчлэлтэй холбоотой 28,237,845.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бүртгэсэн.
2. Данснаас хассан үндсэн хөрөнгөнд ногдох 115,856.9 мянган төгрөгийн дахин үнэлгээний хэрэгжилтийг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Урт хугацаат өр төлбөрийг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.8.2-д заасны дагуу бүртгэлд тусгах мөн хувь нийлүүлэгчээс эргэн төлөгдөхгүй нөхцлөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг дээрхи баримт бичгийн 4.9-ийн 2-д зааснаар бүртгэх.
2. Үндсэн хөрөнгийн данснаас хасах үеийн олз, гарзыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.5.7-д зааснаар бүртгэж, тайлант хугацааны орлогын тайланд тайлагнах.
3. Данснаас хассан үндсэн хөрөнгөд ногдох дахин үнэлгээний зөрүүг хэрэгжсэнд тооцож “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.9.3-д заасны дагуу бүртгэлд тусгаж байх

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Өмчлөгч болох “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаал гарч, урт хугацаат өрийг хааж өмчлөгчийн өмчийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу бүртгэлд тусгав.
2. Зөвлөмжийн дагуу бүртгэж байна.
3. Зөвлөмжийн дагуу 2010 оны санхүүгийн тайланд тусгагдсан данснаас хассан үндсэн хөрөнгийн дүнг Дахин үнэлгээний нэмэгдэл дансанд тусгасаныг 2011 оны 1 дүгээр улирлын тайлан балансад залруулан бүртгэв.

Өртөг, зардлын талаар

1. Үйлдвэрлэлтэй холбоотой тайлант хугацаанд гарсан 3,503,020.5 мянган төгрөгийн шууд болон шууд бус зардлыг тайлант хугацааны удирдлага борлуулалтын зардлаар тайлагнасан.
2. Гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн 15,587.0 мянган төгрөгийн гарзыг үйл ажиллагааны зардлаар ангилж тайлагнасан.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Үйлдвэрлэлтэй холбогдон тайлант хугацаанд гарч байгаа шууд болон шууд бус зардлыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.3-д зааснаар өртгийн объект бүрээр хуримтлуулан бүртгэж, бараа бэлэн бүтээгдэхүүний өртөгт шингээж байх.
2. Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзыг “Нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын баримт бичгийн 4.11-д зааснаар ангилж тайлагнаж байх.

Зөвлөмжийн хэрэгжилт



1. 2011 оны 1 дүгээр улиралд Орон нутгийн салбар үйлдвэрүүд мал төхөөрч, өртөг тооцоолох үйл ажиллагаа явуулаагүй. Зөвхөн удирдлагын шатны зардал гаргасныг хуримтлуулан үйл ажиллагааны зардлаар тайлагнасан.
2. Зөвлөмжийн дагуу санхүүгийн программын жижиг алдааг залруулан 2011 оны 1 дүгээр улирлын тайланг гаргав.

Татварын тооцооллын талаар

1. Тайлант хугацаанд бүртгэсэн найдваргүй авлагын 9,040.5 мянган төгрөгийн зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд татвараас хасагдах зардалд оруулан татварын тооцооллыг хийсэн.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж

1. Орлогын албан татварын тооцооллыг 2006 оны “ААНОТ-ын тухай хууль” ҮТЕГ-ын даргын 2006 оны 235 тоот тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх аргачлал”-ын дагуу хийж байх.

Зөвлөмжийн хэрэгжилт

1. Зөвлөмжийн дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна.



ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

2008-2010 оны хураангуй орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ (%)

Үзүүлэлт	2008	2009	2010
Борлуулалтын орлого	100.0	100.0	100.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	65.3	58.2	49.9
Нийт ашиг	34.7	41.8	50.1
Үйл ажиллагааны зардал	43.0	69.4	51.4
Үйл ажиллагааны ашиг	(8.3)	(27.6)	(1.3)
Татварын өмнөх ашиг	0.12	(20.2)	0.80
Татварын дараах цэвэр ашиг	0.10	(20.2)	0.70

Хүснэгт 16. Хураангуй орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээгээр борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, хүүгийн болон татварын зардлууд нь ашгийн зохих шатлалд хэрхэн нөлөөлж буйг дүгнэвэл:

2008-2010 онуудад борлуулалтын орлого жил дараалан хурдацтай 10 гаран тэрбум төгрөгөөр өссөн байна. Борлуулалтын өсөлтийг дагаад борлуулалтын өртөг, зардал өсөх нь зүйн хэрэг, гэхдээ борлуулалтын өртгийн хувийн жин 2008 онд 65.3 хувь байсан нь 2009 онд 58.2 хувь, 2010 онд 49.9 хувь болж буурсан сайн үзүүлэлттэй байгаа ба нийт ашгийн хувь 34.7–50.1 хувь хүртэл өсчээ. Энэ нь мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг зардлын бууралт гэхээсээ илүүтэй борлуулалтын өртгийг зөвхөн мал мах худалдан авалтын шууд зардлаар тооцсон болон махны худалдах үнийн өсөлттэй холбоотой байх магадлалтай. Нийт ашиг нэмэгдсэн боловч үйл ажиллагааны зардал 2008-2009 онд 2.2 дахин, 2009-2010 онд 27.9 хувиар тус бүр нэмэгдсэн нь үндсэн ажиллагааны үр дүн алдагдалтай гарах шалтгаан болжээ. Үйл ажиллагааны зардал дахь зээлийн хүүний зардлын эзлэх хувь жил ирэх тусам өсч байгаа нь тус компанид зээлийн хүүний зардал дарамт болоод байгааг харуулж байна. Иймд санхүүжилтээ зардал багатай өөр эх үүсвэрээс татах шаардлагатай байгаа нь илэрхийлэгдэнэ. Зээлийн зардал 2009 онд 5.76 дахин, 2010 онд 2009 онтой харьцуулахад 1.55, 2008 болон 2010 онуудыг харьцуулахад бараг 9 дахин өссөн нь харагдаж байна.

2008-2010 оны хураангуй балансад хийсэн хандлагын шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	2008	2009	2010
1 Мөнгө	100%	14%	13%
2 Авлага	100%	940.3%	155.1%
3 Бараа материал	100%	161.7%	65.4%
4 Эргэлтийн хөрөнгийн дүн	100%	190.3%	102.9%
5 Үндсэн хөрөнгө	100%	126.5%	135.6%
6 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100%	122.4%	136%
7 Нийт хөрөнгийн дүн	100%	134.9%	130%
8 Дансны өглөг	100%	468.3%	170.4%
9 Салбарын өглөг	100%	142.5%	49.5%
10 Богино хугацаат өр төлбөрийн дүн	100%	177.2%	98.7%
11 Өр төлбөрийн дүн	100%	154.6%	149.5%
12 Эзэмшигчдийн өмчийн дүн	100%	69.3%	64.9%
13 Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	100%	134.9%	130%

Хүснэгт 17. Балансын хандлагын шинжилгээ

Тус компанийн үндсэн хөрөнгө 2008-2009 онуудад жил дараалан өсч, 2010 онд буурч 2009 оны түвшингээс буурсан ч 2008 оны түвшинтэй харьцуулахад 30 хувиар өссөн



байна. Үүнд авлага, бараа материалын өөрчлөлтүүд голлох нөлөөллийг үзүүлсэн байна. Харин урт хугацаат зээлийн хувьд санхүүжилт жил ирэх тусам өсч байгаа нь харагдаж байна. Нийт эх үүсвэрийн өсөлт нь 2009 онд 1.35 дахин өссөн харагдаж байгаа ч энэ өсөлт зөвхөн зээлийн өсөлт гэж харагдаж байна.

Санхүүгийн тайланд хийсэн харьцааны шинжилгээний үр дүн

<i>Санхүүгийн харьцааны нэр</i>	<i>Тооцсон үзүүлэлт</i>	<i>2008</i>	<i>2009</i>	<i>2010</i>
<i>Төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдалд хийсэн шинжилгээний үр дүн</i>				
Өөрийн капиталын оролцоо, хувь	ӨК:НХ	23.1%	11.9%	11.5%
Эргэлтийн харьцаа	ЭХ:БХӨ	0.97	1.04	1.01
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	(ЭХ-БМ):БХӨ	0.06	0.21	0.41
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн харьцаа	НӨ:ЭӨ	3.33	7.43	7.68
Өрийн харьцаа	ӨК:НХ	0.77	0.88	0.88
Өр төлбөр ба авлагын харьцаа	БХӨ:Авлага	25.2	4.74	16.0
<i>Хөрөнгийн ашиглалт болон компанийн ашигт ажиллагааны байдалд хийсэн шинжилгээний үр дүн</i>				
Нийт хөрөнгийн эргэц	НО:НХ	0.26	0.26	0.47
Өөрийн хөрөнгийн ачаалал	БО:ӨК	1.13	2.19	4.05
Үндсэн хөрөнгийн эргэц	БО:ЭБХ	0.32	0.35	0.55
Авлага цуглуулах дундаж хугацаа	Ав:БО*360		40	25
Бараа материалын эргэц /удаа/	ББӨ:БМ	0.99	0.73	2.68
Ашгийн норм /нийт ашгаар тооцсон/	НА:БО	0.35	0.42	0.5
Ашгийн норм /Ү.А-ны ашгаар тооцсон/	ҮАА:БО	(0.08)	(0.28)	(0.01)
Ашгийн норм /цэвэр ашгаар тооцсон/	ЦА:БО	0.001		0.01
Нийт хөрөнгийн өгөөж	ХТӨЦА:НХ	0.0003	0.0526	0.0038
Өөрийн хөрөнгийн өгөөж	ТӨЦА:ӨК	0.001	(0.443)	0.028

- Компани санхүүгийн тогтвортой байдлын хувьд өөрийн хөрөнгийн оролцоо багассаар 2010 онд 11.5 хувь болсон, тэр хэмжээгээр өрийн харьцаа нэмэгдэж 2008 онд өр төлбөрийн дүн өөрийн хөрөнгөөс 3.3 дахин их байсан нь 2010 онд 7.68 дахин их болж 2 дахин өссөн, эргэлтийн хөрөнгийн харьцаа хангалттай биш (дөнгөж 1.01-1.04) байгаа хүндрэлүүд байна. Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөө ашиглан төлөх чадвар ямар байгааг илэрхийлдэг ба хоёртой ойрхон байх нь хамгийн тохиромжтой гэж үздэг боловч энэ нь салбар болон компанийн онцлогоос шалтгаална. Компанийн ирээдүйн мөнгөн урсгалыг урьдчилан таамаглах боломж их байх тусам эргэлтийн харьцаа бага байх боломжтой байдаг.
- Эргэлтийн хөрөнгийн тогтвортой санхүүжилт дутагдалтай, богино хугацаат төлбөрүүд нь авлагын дүнгээс дунджаар 15 дахин их байгаа нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн тусгайлсан бодлого, зохицуулалт шаардлагатайг харуулж байна.
- Хөрөнгийн ашиглалтын хувьд нийт болон өөрийн хөрөнгийн ачаалал жилээс жилд хурдацтай нэмэгдсэн нь борлуулалтын орлогын өсөлттэй холбоотой бөгөөд авлагын цугларуулалт 40-25 хоног болж түргэссэн нь сайн үзүүлэлттэй байна.
- Ашигт ажиллагааны хувьд өнгөрсөн 3 жилийн хугацаанд тус салбар жил дараалан алдагдалтай ажилласан учраас ихэнх үзүүлэлтүүд сөрөг утгатай гарчээ.

Өмчлөгч болох “Жаст групп” ХХК-ийн Ерөнхий Захирлын 2011 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А-01/18 тоот тушаал гарч, 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өглөг хэсэгт тусгагдсан урт хугацаат өрийн эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр “Жаст Агро” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт болох 28,237,845,241.90 төгрөгийн хөрөнгө оруулалтын хэмжээгээр компани хоорондын тооцооны дүнг бууруулж, “Жаст Агро”



ХХК-ийн эзэмшигчдийн өмчийн дүнг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2011 оны 1-р улирлын санхүүгийн тайланд тусган бүртгэсэн. Энэхүү шийдвэртэй холбоотойгоор Үл хөдлөх хөрөнгүүдийн өмчлөх эрхийг “Жаст Агро” ХХК-ийн нэр дээр шилжүүлэх ажил хийгдэж, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 2011 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр бүртгүүлж, баталгаажуулсан байна.

Ийнхүү өрийн хэмжээ буурснаар нийт эх үүсвэрт зээлийн эх үүсвэрийн эзлэх хувь буюу нийт хөрөнгийн дотор зээлийн эх үүсвэрээр санхүүжигдэж байгаа хэсгийн хувь хэмжээ буурч байгаа таатай үзүүлэлт харагдаж байна.

